

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН БАТАЛСАН ЗАХИРГААНЫ ХЭМ
ХЭМЖЭЭНИЙ АКТЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 08

Мандалговь хот

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, захиргааны хэм хэмжээний актын үр дүнгийн талаар дээд байгууллага болон удирдлагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасан аргачлалын дагуу хийж үнэлгээний дүнг гаргасан.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2019 оны А/393 дугаар захирамжаар батлагдсан "Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох", 2019 оны А/394 дугаар захирамжаар батлагдсан "Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох", аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын даргын хамтарсан 2020 оны А/130, А/18 дугаар захирамжаар батлагдсан "Золбин нохой, муур, тэжээвэр мал, амьтныг сумын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан устгах журам", Байгаль орчин аялал жуулчлалын сайд Аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/427, А/404 дугаар шийдвэрээр батлагдсан "Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай" нийт 4 захирамжийн 36 заалтын жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд хэрэгжилтийн дундаж 93.1 хувьтай байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ

- 1. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 4 суманд дахивар цэг шинээр нэмэгдэж байгуулагдаж, аймгийн хэмжээнд дахивар цуглуулах 7 цэгтэй болсноор нийт 81 тн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж дахивар авах цэгт цуглуулсан. Үүнээс дахин боловсруулах үйлдвэрт 40 тн дахивар нөөц тушаасан.

БАТГАВ
 БАЙГАЛЬ ОРГИЙН ХӨДӨЙЖИЛГЭЭНИЙ
 ГАЗРЫН ДУГАА Т.У.САНХҮҮГИЙН
 ХЭВЧ

"ХИЙРГАМН"
 "Эргүүлж өгөхөд, Мэндэл өргөх" гэсэн санааг тусал

Монгол улсын
 2023 оны 20 дугаар сарын 20-ны өдөр /2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүчин
 гүйцэтгэнэ/

ХИЙРГАМН
 "Эргүүлж өгөхөд, Мэндэл өргөх" гэсэн санааг тусал

Монгол улсын
 2023 оны 20 дугаар сарын 20-ны өдөр /2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүчин
 гүйцэтгэнэ/



Энэ онд 52 ангилан ялгах савыг шинээр байрлуулж нийт 311 хог ангилан ялгах савтай болж өмнөх оноос 52-оор ахисан байна.



Аймгийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын орчмын 50 метр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд сумын нийтийн эзэмшлийн 10 талбайн 15 тн



хогийг, сумдад нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж нийтийн эзэмшлийн 2775,8 га талбайн 815,4 тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн төвлөрсөн цэгт шилжүүлсэн.

2023 оны орон нутгийн хөгжлийн 18.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус бүр 1 тонн даацтай, өөрөө буулгагч, шатахуун зарцуулалт бага, дахивар зөөвөрлөх гурван дугуйт тээврийн хэрэгсэл 2 ширхгийг авч Мандлын гэгээ Хот тохижуулах газар, "Баялаг төв"-д хүлээлгэн өглөө.




Аймгийн төвд Мандалын гэгээ хот тохижуулах газар нийтийн эзэмшлийн зам талбайгаас 3339 тн хог хаягдлыг зөөж тээвэрлэсэн.





2. Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмын хүрээнд:

Агаарын чанарын стандартад нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан болон хийн халаагч төхөөрөмжийг үе шаттай хэрэглээнд нэвтрүүлэх үүднээс НҮБ-ын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газрын хамтран хэрэгжүүлж буй "Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр"-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП төслийн мэдээллийг нийтэд сурталчилснаар энэ төсөлд хамрагдах хүсэлтэй иргэд нэмэгдэж 322 өрх хүсэлтээ ирүүлсэн бөгөөд 2024 онд шинээр 100 өрхийг төсөлд хамруулахаар төлөвлөсөн. Энэ онд 64 өрхөд олгогдсон.



Төвлөрсөн халаалтын зуухнуудад утаа шүүгч байршуулсан.



3. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмын хүрээнд:

Аймгийн төвийн хогийн цэгийн гадуур хог хаягдал асгаж байгааг хянах зорилгоор төвлөрсөн хогийн цэгт 7 хоногт 2 удаа дотоод хяналтыг хийж хэвшүүлсэн. 6 сумын төвлөрсөн цэг хяналтын камертай болсон.



4. Золбин нохой, муур, тэжээвэр мал, амьтныг сумын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан устгах журмын хүрээнд:

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт золбин нохой 2459, муур 235, нийт 2694 муур нохой устгаж ажлын хөлсөнд 63.9 сая төгрөгийг олгосон байна.

Устгал явагдах үед аюулгүй байдлыг хангах, Галт зэвсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан шалгуурыг хангасан, жил бүр тооллогод хамруулсан байдлыг хянаж цагдаагийн байгууллагын алба хаагчид хамтран ажилласан.



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар
10-р сарын 25

ИРГЭДИЙН АНХААРАЛД !!

САЙНЦАГААН СУМЫН ТӨВИЙН БАГУУДЫН ХЭМЖЭЭНД ЗОЛБИН НОХОЙН УСТГАЛ ХИЙЖ БАЙНА

Энэ сарын 23-29-ний өдрүүдэд тусгай зөвшөөрөлтэй гэрээт байгууллагатай хамтран Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, сумын Засаг даргын Тамгын газрын хяналт дор Мандалговь хотын төвийн таван багийн хэмжээнд Золбин нохойн устгалыг хийж байна.

Энэ хугацаанд:

1. Сүрэгтэн бөөгнөрч, эрсдэл үүсгэж байгаа золбин нохойн байршил хаягийг өөрийн харьяа багийн Засаг дарга нарт мэдэгдэх
2. Хуульчтай ч сул чөлөөтэй өвж байгаа нохойг устгах учир цаашид гэрийн тэжээвэр нохойгоо хууль, журамд заасаны дагуу ууж, хараа хамгаалалттай байлгахад анхаарна уу !!

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 10-р сарын 24 өдөр

Мандалговь хот

Энэхүү ажил гүйцэтгүүлэх гэрээг нэг талаас Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг 26-р хороо, мандал овоо 20 гудамж 12 тоот Норов Түвшинтөр /РД: ЧА81092412/ данс: 5024646428 цаашид гүйцэтгэгч гэх/ нар харилцан тохиролцож 420-оос дээш золбин нохой, муур устгахаар байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Мандалговь хотын нутаг дэвсгэрт зэвсэггүй нохой ихэсч иргэдийн аюулгүй байдал алдагдаж, байгаль орчныг бохирдуулж, мал барьж малчдад хохирол учруулах зэрэг сөрөг нөлөө үзүүлж байгаа тул зэвсэггүй золбин нохойг устгах явцад захиалагч гүйцэтгэгч, цагдаагийн байгууллагын холбогдох ажилтны хооронд үүсэх харилцааг

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дундговь аймагт хэрэгжиж буй 4 актын 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 93.1 хувь буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үзэж үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хэрэгжилтийн дүнг хүснэгтээр харуулбал:

Д/д	Шийдвэрийн нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь					Хэрэгжилтийн дундаж хувь
			100	90	70	50	30	
1	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох тухай	12	8	4	-	-	-	96.6
2	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох	11	9		1		1	90.9

3	Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох	6	5			1		91.6
4	Золбин нохой, муур, тэжээвэр мал, амьтныг сумын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан устгах журам	9	6	1	2			92.2
	Дүнгийн нэгтгэл	38	28	5	3	1	1	93.1

ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо		38
Бүрэн хэрэгжсэн		28
Хэрэгжих шатанд		100
		90
		70
Хэрэгжилт хангалтгүй		5
Хэрэгжилтийн хувь		1
		30
		93.1

Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын 3 дугаар зүйлд суманд олон нийтийн байцаагч ажиллуулахаар тусгагдсан боловч Олон нийтийн байцаагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын байцаагч болон мэргэжилтэн хариуцан гүйцэтгэн ажиллаж байгаа учраас олон нийтийн байцаагч ажиллуулах шаардлагагүй, төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар энэ журмын 3 дугаар зүйл хэрэгжихгүй байна.

Хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлэлт удаашралтай байна. Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2023 оны 11 сарын байдлаар 243,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 122,1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөөний биелэлт 50 хувь байгаа нь сумдад байгаль орчны байцаагч, татварын байцаагчийн орон тоо дутагдалтай байгаагаас болж байна гэж үзэж байна. Жилийн эцсийн байдлаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийн бүрдүүлэлт нэмэгдэх боломжтой гэж үзлээ.

Энэ онд Сайнцагаан, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Өлзийт, Цагаандэлгэр, Дэрэн сумуудад золбин нохой 2459, муур 235-ыг устгасан бөгөөд бусад сумд нохой муур устгах ажил хийгээгүй байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Сумдын Засаг дарга нарт:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/394 дугаар захирамжаар батлагдсан “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох” журмын 1,2,3 зүйлд заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлыг сум, байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг

хагас бүтэн жилээр тооцон гаргаж Байгаль, орчин аялал жуулчлалын газарт ирүүлж байх.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сар бүр жигд биелүүлж ажиллах.

Төвлөрсөн хогийн цэгийг хамгаалах, хаших хязгаарлах далан, хашаатай болгох.

Сумын төв, суурин газрын золбин нохой, муурын судалгааг жил бүр гаргаж, устгах тоог тогтоож, түүний дагуу устгалын ажлыг сум бүр зохион байгуулж тайлан мэдээг хагас бүтэн жилээр гаргаж байх.

Хууль эрх зүйн хэлтэс, Байгаль орчин аялал, жуулчлалын газарт:

Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын 3 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах асуудлыг сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгай заалт болгон оруулж хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцож, үр дүнгийн талаарх мэдээллээр удирдлагуудыг хангаж байх.

Журмын хүрээнд хийгдэж байгаа арга хэмжээг олон нийтэд сурталчлах, иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх.


Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн талаар төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн хэмжээний дахивар цуглуулдаг иргэд, ААН байгууллагын мэдээллийг бүрэн цуглуулж, тайланд тусгаж байх.


Захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх асуудлыг байгууллага, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилт үр дүнг тооцож байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилд нэгтгэн тайлагнах асуудлыг Байгаль орчин аялал жуулчлалын газар хариуцаж ажиллах.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Э.ОДОНЧИМЭГ